



2025 оны 05 сарын 08 өдөр

Улаанбаатар хот

СПОРТЫН ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий үндэслэл

- 1.1 Монгол улс дахь Дэлхийн таеквондогийн спортын цолны ангилал тогтоож, олгох үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Монголын таеквондогийн холбоо нь спортын цолны ангилал тогтоох, цол зэрэг олгох асуудлыг хэлэлцэх, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлтэй “цаашид Зөвлөл гэх” байна.
- 1.3 Биеийн тамир, спортын улсын хороо болон Монголын таеквондогийн холбооноос тухайн жилийн улсын хэмжээний тэмцээний /улсын аварга шалгаруулах тэмцээн/ нэгдсэн хуваарийн жагсаалтад багтсан тэмцээнд оролцогчдод цол олгоно.
- 1.4 Монголын таеквондогийн холбоо нь тамирчин, шүүгчийн ёс зүйн дүрмийг олон улсын дүрэмд нийцүүлэн баталж, мөрдүүлнэ.
- 1.5 Спортын цолыг Монгол улсын иргэнд олгоно.

Хоёр. Спортын цолны ангилал

- 2.1 Тамирчин, шүүгчдэд олгох спортын цол нь дараах ангилалтай байна.

2.1.1 Цол:

2.1.1.1 Спортын дэд мастер

2.1.1.2 Спортын мастер

2.1.1.3 Олон улсын хэмжээний мастер

2.1.1.4 Улсын шүүгч

Гурав. Спортын цол олгох

- 3.1 Спортын цолны шалгуур хангасан тамирчин, шүүгчдэд сар бүрийн 25-ны дотор Ерөнхийлөгчийн тушаалаар баталж цолны үнэмлэх, тэмдэг олгоно.
- 3.2 Спортын цолны тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд Биеийн тамир, спортын нэгдсэн цахим сангийн мэдээллийг үндэслэн нэг удаа олгоно.
- 3.3 Спортын цолны үнэмлэх, тэмдгийн хураамж 30.000 (гучин мянга) төгрөг байна.

Дөрөв. Спортын цолны шалгуур

4.1 Спортын дэд мастер

4.1.1 Олон улсын тэмцээнд нэг удаа медальт байранд шалгарвал

4.1.2 Монголын бүх ард түмний спортын их наадамд медальт байрт шалгарвал

4.1.3 Монголын хүүхдийн их наадамд медальт байрт шалгарвал

4.1.4 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд нэг удаа түрүүлбэл

4.1.5 Бага нас, өсвөр үе болон залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээний А ангилалд 2 удаа түрүүлбэл, эсвэл 4 удаа медальт байрт шалгарвал

4.2 Спортын мастер

4.2.1 Олон улсын тэмцээн буюу тухайн жингийн ангилалд 5 ба түүнээс дээш орон орсон тэмцээнд 2 ба түүнээс дээш медальт байрт шалгарвал

4.2.2 Монголын бүх ард түмний спортын их наадамд түрүүлбэл

4.2.3 Монголын хүүхдийн их наадамд түрүүлбэл

4.2.4 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээний А ангилалд 3 удаа түрүүлбэл

4.2.5 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлбэл, эсвэл нэг удаа түрүүлж, 2 удаа хоёрдугаар байрт шалгарвал

4.2.6 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт 5 удаа шалгарвал

4.3 Олон улсын хэмжээний мастер

4.3.1 Олимп болон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 4 байрт шалгарвал

4.3.2 Тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байранд,

4.3.3 Өсвөр үе, Залуучуудын дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал

4.3.4 Олон улсын А зэрэглэлийн тэмцээн буюу тухайн жингийн ангилалд 5 ба түүнээс дээш орон орсон тэмцээнд 2 удаа түрүүлбэл

4.3.5 Дэлхийн таеквондогийн холбооноос 5 дан ба түүнээс дээш дан авбал

4.3.6 Олимпын наадмын эрх авбал

4.4 Улсын шүүгч

4.1 Улсын чанартай тэмцээнийг шүүсэн туршлага, шүүгчийн мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал, холбооны шүүгчийн зөвлөлийн шалгалтын дүн, шийдвэрийг үндэслэн

Тав. Спортын цол болзол биелүүлсэн тамирчны бүрдүүлэх материал

5.1 Бүрдүүлэх материал:

5.1.1 Цээж зураг

5.1.2 Төрсний гэрчилгээ ба түүнтэй адилтгах бичиг баримтын хуулбар

5.1.3 Олон улс болон улсын хэмжээний тэмцээний медальт байрт шалгарсан өргөмжлөлийн хуулбар

5.1.4 Спортын цолны анкет

5.2 Спортын цолны шалгуур хангасан тамирчин, шүүгчдийн материалыг сар бүрийн 20-ны дотор Монголын таеквондогийн холбоо хүлээн авна.